

**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2018 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/228

Булган

┌ Агаар мандалд зориудаар ┐
нөлөөлөх тухай

Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.2 дахь заалт, Засгийн газрын 2007 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан “Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль, цаг агаарын бодит судалгаа, дүгнэлтэд үндэслэн шаардлагатай тохиолдолд 2017 оны 04 дүгээр сарын 20-ноос эхлэн агаар мандалд зориудаар нөлөөлж, хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж ажиллахыг Ус, цаг уур, орчны шинжилгээний газар /С.Жаргалсайхан/, Онцгой байдлын газар /Ш.Баасандорж/, Хүнс, хөдөө аж ахуйн газар /Ч.Амгалан/-т тус тус даалгасугай.

2. Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын баталсан “Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг зохицуулах дүрэм”-ийг мөрдөж, хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг олон улсын болон орон нутгийн нислэгийн аюулгүй байдалтай уялдуулан зохион байгуулж, хамтран ажиллахыг Иргэний нисэхийн Ерөнхий газрын харьяа “Булган” нисэх буудлын дарга /Б.Баасанбат/, Ус, цаг уур, орчны шинжилгээний газар /С.Жаргалсайхан/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Агаар мандалд зориудаар нөлөөлөх экспедицийг тухайн орон нутагт ажиллах нөхцөл, боломжоор хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт чиглэл болгосугай.

4. Шатахуун, томилолтын зардлыг тухай бүр нь шийдвэрлэж ажиллахыг аймгийн Онцгой комисст хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ